

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ 2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016.06.27

Улаанбаатар хот

Эрх зүйн шинэтгэл, хууль зүйн нэгдсэн бодлого, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, хууль зүйн боловсрол, эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах, хуульчдын өөрөө удирдах байгууллагатай харилцах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд чиглэсэн дор дурдсан ажлыг 2016 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ, СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

1.1. Улсын Их Хурлын чуулганаар батлагдсан хуулийн талаар:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг 6 хуулийн төслийг боловсруулан УИХ-аар батлуулсан.

1.2. Улсын Их Хуралд өргөн баригдсан хуулийн төслийн талаар:

Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Дотоодын цэргийн хуулийн төсөл, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг 6 хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн.

1.3. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн, хэлэлцүүлсэн:

Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төслүүдийг боловсруулж, холбогдох байгууллагаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

1.4. Боловсруулалтын шатанд байгаа хуулийн төслийн талаар:

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай хуулийн төсөл, Архивын тухай хуулийн төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, салбарын хуулийн давхардал, хийдэл зөрчлийг арилгах зорилгоор 13 хуульд нэмэлт, өөрчлөлт зэрэг хуулийн төслүүд боловсруулалтын шатанд байна.

1.5. Шинээр батлагдсан хуулиудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”-ын төслүүдийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан.

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-уудын дагуу зарим хуулиудад үнэлгээ хийхээр холбогдох байгууллагуудаас судалгааг авч дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж байна.

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-уудаар УИХ, ЗГ, яамд, агентлагуудад сургалт зохион байгуулах төлөвлөгөөг батлуулан

сургагч багш бэлтгэх сургалтыг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төсөлтэй хамтран зохион байгуулсан.

Хууль зүйн сайдын тушаалаар Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн талаарх сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын 2016 оны төлөвлөгөөг батлуулан сургагч багшийн гарын авлага боловсруулах болон төрийн болон төрийн бус байгууллагуудад сургалт зохион байгуулж, иргэдэд зориулсан радио жүжгийг бэлтгэн 19 ангийг олон нийтэд түгээгээд байна.

Давхардсан тоогоор 18 удаагийн сургалтаар 26 байгууллагыг хамруулан 8 танилцуулга, хуулиудын 6 удаагийн хэвлэлтийг бэлтгэн гаргасан.

ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН НЭГДСЭН БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүдийн санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт боловсруулах:

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын санаачилсан Ашигт малтмалын хуульд өөрчлөлт оруулах, УИХ-ын гишүүн Бакейн санаачилсан УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн хуульд нэмэлт оруулах, Ард нийтийн санал асуулгын тухай, Иргэний харьяаллын тухай, УИХ-ын гишүүн М.Батчимэгийн санаачилсан Гадаад харилцааны тухай, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнийн санаачилсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын санаачилсан ашигт малтмалын хуульд нэмэлт Хурдан морины бооцоот уралдааны тухай, Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярын санаачилсан Малчдын нийгмийн баталгааны тухай, Н.Батбаярын санаачилсан Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах, УИХ-ын гишүүн Д.Ганбатын санаачилсан Боловсролын тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт оруулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдоржийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгын санаачилсан Үйл ажиллагааны түрээсийн тухай зэрэг 42 хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төслийг боловсруулж, хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

2.2.Бусад яамдаас ирүүлсэн хууль тогтоомжийн үзэл баримтлалын төслийг хянаж, батлах чиглэлээр:

Хөдөлмөрийн тухай, Аялал жуулчлалын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Усан замын тээвэр, авто тээврийн тухай, Гаалийн тухай, Аялал жуулчлалын тухай, Эх хүүхдийн эрүүл мэндийн тухай, Хөдөлмөрийн тухай, Усан замын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч авах тухай хууль, Иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах, Гаалийн болон НӨАТ-с чөлөөлөх, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль, Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай, Зээлийн ерөнхий хэлэлцээр батлах тухай, Авто зогсоолын тухай зэрэг нийт 45 хуулийн үзэл баримтлалыг хянан баталж хүргүүлэв.

2.3.Хуулийн төсөл, УИХ-ын тогтоолын төсөл хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгох чиглэлээр:

2016 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт батлах тухай, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай, Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Эдийн засаг, нийгмийг 2017 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр батлах тухай, Халх гол бүтээн байгуулалтын тухай, Хэнтий хан уулыг бурхан халдун хайрхан болгож нэрийг өөрчлөх тухай, Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай, ХАА-н халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай зэрэг нийт 32 хууль, тогтоолын төслийг эцэслэн хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

2.4. Засгийн газрын шийдвэрийн төсөлд өгөх санал боловсруулах чиглэлээр:

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Нэрэмжит болгох тухай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих тухай, сургалтын дундаж нормативт зардал, үндэсний стратеги батлах тухай, Эрдэнэс монгол ХХК-г өрийн баталгаа гаргах тухай, Цаг уур орчны шинжилгээний сүлжээний өргөтгөлийн

талаар, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр, Тусгай зориулалтын автомашины жагсаалт батлах, Биеийн тамир спортын зарим барааг гаалийн татвараас чөлөөлөх, хөрөнгө гаргах, Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, Орон сууцыг үнэтэй хувьчлах, Талбайг нөөцөөс чөлөөлөх, Дэлхийн монголчууд хөтөлбөр, Хэлэлцээр батлах, Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын төвийн талаар авах арга хэмжээний тухай, 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр санхүүжилт, төлөвлөгөө батлах тухай, Концессын гэрээ байгуулах эрх олгох, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх, Эрүүл мэндийн даатгалын цахим сангийн дүрэм, Улсын тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хөлсний хэмжээ тогтоох тухай, Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай, Тост, тосон бумын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг батлах тухай, Эрчим хүчний аудит хийх журам, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсээс чөлөөлөх тухай, Азийн ойн хамтын ажиллагааны байгууллагын хэлэлцээр батлах тухай зэрэг Засгийн газрын **230** тогтоолын төсөлд холбогдох санал боловсруулан хүргүүлэв.

Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох, Түрээсийн төлбөрийн жишиг үнэ, гэрээний сунгалтын загвар, сонгон шалгаруулах, гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах үйл ажиллагаанд хэрэглэх баримт бичгийн загвар зэрэг **10** шийдвэрт хууль зүйн дүгнэлт хүргүүлж, **3** шийдвэрийг буцааж, **2** шийдвэрт зөвлөмж хүргүүлсэн.

2.5. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хянаж бүртгэх болон улсын нэгдсэн сангийн талаар:

“Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”, Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийн цахим хувийг үйлдэх, баталгаажуулах, хүлээлцэх журам”, “Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, системчлэн ангилж, хууль тогтоомжийн хувийн хэрэг хөтлөх журам” зэрэг **4** журмыг шинэчлэн боловсруулж, Хууль зүйн яамнаас боловсруулсан **16** журмыг хянасан.

Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.

2016 оны эхний хагас жилд холбогдох байгууллагаас батлан гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон **48** шийдвэрийг хянан бүртгэж, улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа **18** актад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн авч холбогдох хөдөлгөөнийг хийж, санд бүртгэлтэй байсан **16** шийдвэрийг хүчингүй болгож, ИТХ-ын **2** шийдвэрийг санд хүлээн авч, өөрчлөлт хөдөлгөөнийг legalinfo сайтад байршуулан хяналтын хувь дээр тэмдэглэгээ хийсэн.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй 940 шийдвэрт хяналт шинжилгээ хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2016 онд батлагдсан эрх зүйн актуудыг хяналтын хувьтай тулгалт хийж, нэмэлт өөрчлөлт, хүчингүй болсон хөдөлгөөний дутуу хийгдсэн алдааг засаж, холбогдох байгууллагын мэдээлэл оруулагч нартай хамтран ажиллаж, хяналтыг байнга тавин ажиллаж байна.

legalinfo цахим сангийн хүчингүй хувилбарт байгаа 1992-2014 оны хуулиудын хэлбэржилтийг засч, цахим сангийн нэмэлт өөрчлөлт гэсэн хувилбарт харагдахгүй байсан нэмэлт, өөрчлөлтийг нөхөж шинээр нэмж хийсэн.

Улсын бүртгэлд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн хүчинтэй жагсаалтыг Хууль зүйн мэдээлэл сэтгүүлд нийтэлсэн.

2.6.Хууль тогтоомжийн бүртгэл-лавламжийн үндэсний санг бүрдүүлэх, зохих журмын дагуу хөтлөх, системчлэх, картын санг бүрдүүлэх талаар:

Хууль тогтоомжийн үндэсний санд Хууль /нэмэлт, өөрчлөлт/-161, УИХ-ын тогтоол-57, Ерөнхийлөгчийн зарлиг-12, Засгийн газрын тогтоол-202, ҮХЦ-ийн тогтоол-9, Ерөнхий сайдын захирамж-9, нийт **458** эрх зүйн акт бүртгэгдсэн.

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд бүртгэгдсэн актаас хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт -270, УИХ, ЗГТ, Ерөнхий сайдын захирамж, ҮХЦ-ийн тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлт-154 актаар/давхардсан тоогоор/ нийт **427** актаар **641** эх хувьд хөдөлгөөнийг тусгалаа.

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн сангаас 88 ажилтанд давхардсан тоогоор 224 актаар лавлагаа мэдээллийг эх хувиас өгсөн.

Шинээр бүртгэгдсэн актаар Able-"олон нийт" гэсэн хэсэгт 20 удаа мэдээллийг оруулж нийтэд мэдээлсэн байна.

Эрх зүйн актын нэгдсэн ангилагчийг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлын хэсэг Хууль зүйн сайдын 2016 оны А/142 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Салбарын хууль тогтоомжийн жагсаалтад шинээр батлагдсан актаас хэм хэмжээ тогтоосон актыг ялган холбогдох салбарын жагсаалтад нэмж орууллаа.

ГУРАВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

3.1. Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлт, яамны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хяналт тавьж тайлагнах, хүрээнд:

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тайлан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлан мэдээ, хууль тогтоомж, ЗГ-ын тогтоол, шийдвэрийн биелэлт, Хууль зүйн сайдын эрхлэх хүрээний асуудлаар УИХ, Засгийн газраас баталсан 6 үндэсний хөтөлбөр түүний төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган хуулийн хугацаанд танилцуулсан.

Яамны үйл ажиллагааны тайланг сар бүр гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Яамны үйл ажиллагааны жил, 1, 2 дугаар улирлын төлөвлөгөө, Хууль зүйн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгавар, Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Яамны Авлигын эсрэг 2016 оны төлөвлөгөөг боловсруулан ТНБД-аар батлуулан ажиллаж байна. Яам, харьяа байгууллагын албан хаагчдын 2015 оны Ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд АТГ-т хүргүүлсэн.

Төрийн нууцад хамаарах ирсэн, явсан бичгийн мэдээлэл, биет зүйлийн бүртгэлийг тухай бүр хөтлөн, журмын дагуу хадгалж байна.

Хууль зүйн яам болон харьяа агентлаг, байгууллагын 2012-2016 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэн, хэвлүүлж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн тараасан. Мөн ХЗЯ-наас батлан гаргасан бодлогын баримт бичгийн эх бэлтгэн 300 ширхэг эмхэтгэл хэвлүүлэн албан хэрэгцээнд ашиглаж байна.

2016 оны эхний хагас жилд Ерөнхий сайдтай хийсэн 3 удаагийн теле хурлын бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулсан.

Дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн байдлын талаар харьяа 11 агентлаг, байгууллагын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, тогтмол мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

3.2. Хүний нөөцийн манлайллыг хангах, төрийн албаны салбар зөвлөлийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр:

Хууль зүйн яам болон харьяа агентлаг, байгууллагын албан хаагчдын 2015 оны бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, Яамны ТА3-ийн салбар зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэж, бааз бүрдүүлэн, тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Яамны ТА3-ийн салбар зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ажилтнуудын 2016 оны сургалтын төлөвлөгөө, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх арга хэмжээний төлөвлөгөөг Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хууль зүйн сайдын 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн А/32 дугаар тушаалаар 36 албан хаагчид зэрэг дэв, 2016 оны 4 дүгээр сарын 1-ний А/104 дүгээр тушаалаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 7 албан хаагчид тус тус олгуулсан.

Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын дарга, дэд дарга нарын 2016 оны ээлжийн амралтын хуваарь, Хууль зүйн яамны албан хаагчдын 2016 оны ээлжийн амралтын хуваарийг ТНБД-ын тушаалаар батлуулсан.

Тайлангийн хугацаанд хүний нөөцийн томилгоотой холбоотой ХЗС-ын 9 тушаал, ТНБД-ын 9 тушаал, яамны ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр ТНБД-ын 25 тушаал батлагдан гарсан байна. Мөн 9 ажилтанд 2.900.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг ТНБД-ын тушаалаар олгосон.

3.3. Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд:

Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан.

Хууль тогтоомжийн төсөлд жендерийн үнэлгээ хийх, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэн, Засгийн газрын тогтоолоор батлуулсан.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явцын тайланг авах, дүн шинжилгээ хийж, Жендерийн үндэсний хороонд хүргүүлсэн.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Жендерийн ажлын алба, Хүн амын сантай хамтран “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх Хууль сахиулах байгууллагуудын жендерийн нэгдсэн бодлого”-ын баримт бичгийг боловсруулж байна. Уг ажлын хүрээнд “Ажлын байран дахь бэлгийн дарамт түүнээс урьдчилан сэргийлэх арга зүй” сэдэвт сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн албан хаагчдад зохион байгуулсан.

Мөн “Хууль сахиулах салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт хурлыг зохион байгуулж, “Хууль сахиулах салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо”, “Хүчирхийллийн эсрэг тэмцэхэд эмэгтэйчүүдийн үүрэг роль”, “Цагдаагийн байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцоо”, “Энхтайван ба аюулгүй байдлын асуудалд эмэгтэйчүүдийн оролцоо”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, Хууль зүйн яамны төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудад хийсэн жендерийн үнэлгээний тайланг танилцуулсан.

3.4.Боловсон хүчний мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах, яамны аппаратын албан хаагчдыг гадаад, дотоод сургалтад хамруулах чиглэлээр:

Хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхижуулах зорилгоор төрийн албан хаагчдыг боловсролын зэрэг олгох болон ажлын байран дээрх сургалтыг тогтмол зохион байгуулсан.

Удирдлагын академийн магистрийн сургалтад 1 албан хаагч, бусад их сургуулийн магистрийн сургалтад 2 албан хаагч, АНУ-д 1 албан хаагч сургалтад хамрагдсан.

Шинэ ажилтны сургалт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалт, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах тухай, төрийн нууцтай хэрхэн харилцах тухай, “Байгууллагын архивт баримт хүлээлгэн өгөхөд бэлтгэх” сэдэвт сургалт, Ганабелл институттэй хамтран “Бидний санаачилга–Байгууллагын хөгжил” сэдэвт сургалт, Монголын Хуульчдын Холбоотой хамтран хуульчийн гэрчилгээтэй ажилтнуудад зориулан кредит багц цаг олгох 2 өдрийн сургалт, Кибер аюулгүй байдлын газартай хамтарсан сургалтуудыг тус тус зохион байгуулсан. Мэдээллийн цагийг хуваарийн дагуу зохион байгуулсан.

3.5.Шагнал урамшууллын талаар:

Тайлангийн хугацаанд 143 хүн төрийн одон медалиар, Хууль зүйн албаны тэргүүний ажилтан тэмдгээр 79, Яамны Хүндэт жуух бичгээр 110, Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан тэмдгээр 4, Цагдаагийн алдар тэмдгээр 39, Хүндэт хилчин тэмдгээр 6, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тэргүүний ажилтан тэмдгээр 5 хүн шагнагдсан байна.

3.6.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хэрэгжилтийн байдалд хяналт тавих талаар:

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хууль болон “Хууль зүйн яаманд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын хүрээнд иргэдэд үйлчлэх, иргэдийг сонсох, иргэдээс гаргаж буй өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Тайлангийн хугацаанд иргэд, байгууллагаас **356** өргөдөл, гомдол хүлээн авснаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас **11**, Улсын Их Хурлаас **19**, иргэдээс биечлэн **267**, шуудангаар **89** өргөдөл, гомдол хүлээн авч, **328 (92.1%)** өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн өргөдөл гаргагчид хариу өгч, хугацаа болоогүй **28 (7.9%)** өргөдөлд хяналт тавин ажиллаж байна.

Сайдын иргэд хүлээн авах уулзалтыг 2 удаа зохион байгуулж, 31 иргэнтэй Сайд биечлэн уулзаж, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын санал хүсэлт хүлээн авах 11-11 төвөөс тус яаманд **73** санал, хүсэлт хуваарилан ирүүлснээс хариу өгсөн 59, хяналтад 17 санал байна.

3.7.Дотоод хяналтын чиглэлээр:

Яамны Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан ТНБД-аар батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Төлөвлөгөөний дагуу “Архивын улсын байцаагчийн 2015 оны 01/15 дугаартай дүгнэлтийн хэрэгжилтийг шалгах”, “Яаман дээр хэрэгжиж буй цахим програмын хэрэглээний хэрэгжилт /архив, өргөдөл, гомдол, номын сан, Able/, “Гадаадын их, дээд сургуульд суралцагчдыг сонгон шалгаруулах, суралцуулах”, Төрийн нарийн бичгийн даргын 2014.06.24-ний А/68 дугаар тушаалаар баталсан “Ажил хүлээлцэх журам”-ын хэрэгжилт, “Байгууллагын архивт баримт шилжүүлэх журам”-ын хэрэгжилтийг шалган дүнг удирдлагад танилцуулсан.

Тайлангийн хугацаанд ирсэн албан бичиг нийт-**5336**, шууд буюу хариугүй- **3888**, үүнээс хариутай -**1448**, хугацаанд шийдсэн-**715**, шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн бичиг-**24**, хугацаа хоцорч шийдвэрлэсэн -**113** бичиг байна.

Явсан бичиг нийт - **2260**, албан бичигт огноо, дугаар өгч - **3287** бичгийг нэг бүрчлэн дугтуйлж, дотоодын албан байгууллага, гадаад-**31** /дипломат шуудан/, хувь хүмүүст хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Бичиг хэрэгт төвлөрөн хадгалагдаж буй /2015 оны явуулсан бичиг/ баримт бичгийг цахимд бүртгэлд оруулах ажил хийгдэж байна.

Баримт бичгийн шийдвэрлэлтийн талаарх мэдээ, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 7 хоног, 14 хоног тутам гаргаж, Төрийн нарийн бичгийн дарга, ТЗУГ-ын даргад танилцуулан ажилласан.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг цахим бүртгэл /Able/-д бүртгэн Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, холбогдох нэгжийн дарга нарт танилцуулан сан хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

Тайлангийн хугацаанд 7 төрлийн 8600 ширхэг хэвлэмэл хуудсыг дугаарлаж, бүртгэлийн дэвтэр хөтлөн, нийт 8512 ширхэг албан тоот, Хууль зүйн албаны тэргүүний ажилтан, Хүндэт жуух, албан хаагчдын үнэмлэхийг тусгай хэвлэмэл хуудас дээр хэвлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Байгууллагын 2016 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, 2016 оны 1-3 дугаар улирлын хэвлэл захиалгын хуваарь, Байгууллагын архивт баримт шилжүүлэх хуваарь, Бичиг хэргийн индексийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар шинэчлэн батлуулсан.

Яамны архивын байнга хадгалах 2000-2012 оны 1224 хадгаламжийн нэгж баримтад дахин нягтлан шалгалтын ажлыг хийж, данс бүртгэлийг шинэчлэн 2016 оны 05 сарын 11-ний өдрийн байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлсэн.

Тайлангийн хугацаанд гадны байгууллага, иргэдэд 33 удаа 300 гаруй хуудас, байгууллагын албан хаагчдад 130 удаа 1000 гаруй хуудас баримтын хуулбар болон 20 удаа нийт 100 гаруй боть архивын баримтыг түр хугацаагаар олгосон.

Яамны 1992-2000 оны 300 гаруй баримтыг цахим хэлбэрт оруулж, данс бүртгэл, дотоод товъёогийг архивын програмд шивэх ажил хийгдэж байна. Энэ ажлын хүрээнд нийт 70 гаруй хадгаламжийн нэгжийн нийт 6763 хуудас сканнердаж цахим хэлбэрт оруулсан.

3.8. Эрх зүйн мэдээллийн цахим сангийн техникийн хэвийн ажиллагааг хангах, яамны мэдээллийн сүлжээ, бусад сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх чиглэлээр:

Тус яамны нийт компьютер, техник хэрэгсэл, дотоод сүлжээ, Able систем, сервер, интернетийн өдөр тутмын хэвийн ажиллагааг ханган ажиллаж, тэдгээрийн засвар, үйлчилгээтэй холбоотой 3-7 дуудлагыг хүлээн авч шаардлагатай засвар, үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Able системд хийгдэж буй шинэчлэлтийн ажлууд болон хийгдсэн ажлуудын талаар программыг хөгжүүлэгчидтэй холбоотой ажиллаж, тогтмол хяналт тавин ажиллаж байна. Уг програмын албан бичиг, цаг бүртгэл, олон нийт хэсгийн функцийг шинэчилж, сонголтыг нэмэгдүүлэн өөрчлөлт хийсэн.

2016 оны эхний хагас жилийн байдлаар Able програмд:

- Хурлын танхимын хуваарь - 25
- Зар - 24
- Мэдээ, мэдээлэл - 36
- Хоцорсон албан хаагчдын мэдээлэл - 8
- Шинээр бүртгэсэн - 6
- Албан тушаал өөрчлөгдсөн - 4
- Чөлөөлөгдсөн - 4 албан хаагчийн мэдээллийг оруулсан.

Албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдлын мэдээг сар бүрийн 20-ны өдрөөр тасалбар болгон гаргаж ТЗУГ-ын дарга, ТНБД-д танилцуулсан.

Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, яамны үйл ажиллагааг мэдээлэх хүрээнд сонин, ТВ-тэй байгуулсан гэрээний дагуу сэдэв, хугацаа, хуваарийг батлуулан, хуваарийн дагуу ажлыг зохион байгуулсан.

ХЗЯ-наас боловсруулан батлуулсан, УИХ-д өргөн мэдүүлсэн, боловсруулж байгаа хуулиудын талаар өдөр тутмын сонин, радио, цахим сайт, телевизээр тодруулга мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна.

Хууль зүйн яамны албан ёсны вэб сайтад цаг үеийн мэдээллийг тогтмол шинэчилэн, 139 мэдээ бэлтгэж, 122 мэдээ нийтэлсэн байна.

Хууль зүйн яамны харьяа агентлаг, байгууллагуудын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтан албан хаагч нарт сургалт зохион байгуулж, “Мэдээллийн аюулгүй байдлын талаар анхаарах асуудал” болон Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр батлагдсан хуулиуд болох “Захиргааны ерөнхий хууль”, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”, “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай хууль”-ийн талаар тус тус танилцуулга хийлээ. Мөн хууль зүйн салбарын үйл ажиллагаанд холбогдох мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх журмыг танилцуулав.

Өдөр тутмын хэвлэлээр гарсан мэдээллийн мониторинг хийж, удирдлагуудад танилцуулах хүрээнд Хууль зүйн яамтай холбогдолтойгоор цаг үеийн онцлох, анхаарал татсан улс төрийн болон Засгийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийн мониторинг хийсэн.

Хууль зүйн яамтай холбоотой хурал, зөвлөгөөн, сургалт, сурталчилгаа, уулзалт гэх мэт үйл ажиллагааны зургийг архивлан /2016 оны 6 дугаар сар 06/ өдрийн байдлаар 109 фолдэр бүхий 24 гв фото зургийн сан бүрдүүлэн архив үүсгэсэн. Видео архивыг тухай бүр бүрдүүлэн компьютерт тусдаа фолдер нээсэн.

3.9. Албан хаагчдын эрүүл мэндийн чиглэлээр:

Яамны аппаратын нийт албан хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж, нарийн мэргэжлийн эмч нарын тусламж авахад дэмжлэг үзүүлж, эмчийн кабинетэд эмийн ба эмийн бус эмчилгээг цаг тухайд нь хийж, зөвлөгөө өгч ажилласан.

Яамны албан хаагчдын эрүүл мэндийн талаар 2016 онд хийх ажлын төлөвлөгөө гаргаж,ТЗУГ-ын даргаар батлуулан ажиллаж байна.

Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Харшлын тухай ерөнхий ойлголт, харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Дархлааны тухай ерөнхий ойлголт, дархлааны тогтолцооны тухай” сэдвээр мэргэжлийн багш, эмчээр мэдээлэл хийлгэсэн.

“Able” дотоод сүлжээнд “Антибиотикийн хэрэглээ, антибиотикийг хэзээ хэрэглэх вэ?”, “Элгээ цэвэрлэж эрүүлжүүлье”, “Харшлын тухай ерөнхий ойлголт”, “Дархлааны тухай ерөнхий ойлголт”, “Ургамлын тоосны харшил”, “Эмний харшил”, “Харшилтай хүүхдэд анхаарах зүйлс”, “Нурууны өвдөлт гэж юу вэ?” зэрэг сэдвүүдээр зөвлөмжүүдийг байршуулсан.

ДӨРӨВ. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн урсгал зардлын төлөвлөгөөг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах талаар:

Төсвийн тухай хуулийн дагуу Хууль зүйн сайдын багцын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд аудит хийлгэж, Үндэсний аудитын газрын “зөрчилгүй” санал дүгнэлтийг хүлээн авсан.

Хууль зүйн сайдын багцын төсвийн төвлөрүүлэн захирагчид болох Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тахарын ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, шууд захирагчид болох Архивын ерөнхий газар, Хууль зүйн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төв, Хууль сахиулахын их сургууль, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Хорихын нэгдсэн эмнэлэг, Банк хадгаламж зээлийн хоршооны ажлын алба зэрэг нийт 210 төсөвт нэгжийн 2015 оны санхүүгийн аудитлагдсан санхүүгийн тайланг Plastic програмаар шивж нэгтгэн, Хууль зүйн сайдын багцын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан нэгтгүүлэв.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар Хууль зүйн сайдын төсвийн багцад 10 хөтөлбөр, 27 арга хэмжээнд зориулан 383 828.5 сая төгрөгийн урсгал зардал, 8 021.2 сая төгрөгийн хөрөнгийн зардал, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх зээлийг 22 177.1 сая төгрөгөөр, нийт зарлагын дүн 391 849.7 сая төгрөг, цэвэр зээлийн дүнг оруулсанаар 369 672.6 сая төгрөгт багтаан, улсын төсвөөс 398 562.2 сая төгрөг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 10 855.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5416.9 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 962.3 сая төгрөгийг тус тус баталсан.

Эхний 5 сард 166,256.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан бөгөөд улсын төсвөөс 140,450.1 сая төгрөг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 23,047.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 2,438.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 320.8 сая төгрөгийн санхүүжилтийг баталсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 159,008.4 сая төгрөгийг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,868.8 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,474.3 сая төгрөгийг, эрүүл мэндийн даатгалын сангаас 305.4 сая төгрөгийг нийт 164,656.9 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж 157,157.9 сая төгрөгийг зарцуулж 7,499.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй харьцуулахад 99.03 хувь, олгосон санхүүжилттэй харьцуулахад 95.44 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Салбарын эхний 5 сарын байдлаарх төсөвт нэгжийн авлагын сарын эхний үлдэгдэл 676.2 сая төгрөг байсан бөгөөд 145.8 сая төгрөгөөр буурч 530.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан.

Өглөгийн сарын эхний үлдэгдэл 4,799.0 сая төгрөг байсан бөгөөд хугацааны дундуур 668.0 сая төгрөгийн өглөг нэмэгдэж 5,467.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

4.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах талаар:

Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг боловсруулж сайдын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А/07 туушаалаар батлуулж, Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Засгийн газрын 2001 оны 122 дугаар тогтоолын хавсралтад цагдаа, хил хамгаалах байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тахарын алба болон хууль сахиулах байгууллагуудын нормын хувцас хэрэглэл болон ШШГЕГ-ын барилга байгууламжуудыг төрийн нууцад хамааруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж батлуулсан.

Хууль зүйн сайдын багцад 2015 онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийн нэгдсэн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн.

Хууль зүйн сайдын багцын 2015 оны Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн шалгалтын ажлын хэсэгт төсөв хөрөнгийн тооцоо, гүйцэтгэлийг төсөл нэг бүрээр гаргаж дүнг баталгаажуулсан.

Тус яамны захиалгаар баригдсан дуусаагүй барилга хуучнаар төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн барилгыг Эрүүл мэнд, спортын яаманд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2016 оны 134 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн.

БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсад үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх Цагаан шонхор ТӨУҮГ-ын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах төсөл, ШШГЕГ-ын хэмжээнд хаягдал цаасны үйлдвэр байгуулах төсөл, Шүүхийн шинжилгээний орон нутаг дахь албадууд болон шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх төслүүдийн мэдээллийг хянаж нэгтгэж байна.

Хил хамгаалах байгууллагын хилийн цэргийн ангиудын орчин нөхцөл сайжруулах төсөл, Сэлэнгэ аймаг дахь хуульчдын олон улсын сургалтын төв байгуулах зэрэг 5 төслийн мэдээллийг хянаж нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн.

Хууль зүйн сайдын багцын хэмжээнд 2016 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний 1 дүгээр улирлын тайланг гаргаж, 2016 оны 4 дүгээр сарын 15-нд Сангийн яаманд хүргүүлсэн.

Сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2015 онд төсвийн орлого бүрдээгүйгээс санхүүжилт хийгдээгүй 80-90 хувийн гүйцэтгэлтэй төслүүдийн санхүүжилтийг 2016 онд векселээр олгох саналыг Сангийн яаманд хүргүүлсэн.

Сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2016 онд хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас тусгай зориулалтын 200,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авах санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг хянаж хүлээлцсэн актыг хянаж баталгаажуулсан.

4.3. Яамны санхүүгийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах талаар:

Төсвийн урсгал санхүүжилтэд эхний 5 сарын байдлаар нийт 1,352.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 924.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч, харилцахаар 259 удаагийн төлбөрийн хүсэлтээр 785.3 сая төгрөг, кассаар 40 удаагийн 5,3 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч бичилт хийсэн.

Албан хаагчдын цалинг хуваарийн дагуу бодож олгоод байгаа бөгөөд нийт 99 албан хаагчид 593.0 сая төгрөгийн цалин бодогдсон бөгөөд нийгмийн даатгалын дэвтрийн бичилтийг сар бүр хийж бичилтийг баталгаажуулсан.

Шилэн дансны тухай хууль, журмын дагуу яамны батлагдсан төсөв, 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого зарлагын гүйлгээ, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт болон бусад заасан мэдээллийг цаг хугацаанд нь www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж байна.

4.4. Төрийн сангийн төлбөр тооцоо

Хууль зүйн салбарын 2016 оны батлагдсан төсвийн хүрээнд яамны төрийн сан дээр төлбөр тооцоо хийгддэг харьяа 43 төсвийн байгууллагуудын 144 дансаар төлбөр тооцоог цахим системээр 2016 оны 1 сарын 01-ээс 6 сарын 13 хүртэлх хугацаанд 10278 ширхэг баримтаар 66 тэрбум 510 сая төгрөгийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг хүлээн хянан, бүртгэж, баталгаажуулж дамжуулсан.

Хууль зүйн салбарын 200 гаруй төсвийн байгууллагын 2016 оны эхний 5 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн, тайлбар тодруулгын хамт хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн.

Хууль зүйн салбарын болон харьяа агентлаг, байгууллагуудын нийт 94 жижиг мөнгөн сангийн зарцуулалтын тайланг хянаж, журналд бүртгэн эрхийг нээсэн.

Харьяа төсвийн байгууллагуудаас төрийн санд ирүүлсэн төсвийн гүйлгээтэй холбоотой 55 албан хүсэлтийг хууль журмын дагуу шийдвэрлэсэн.

ТАВ. ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

5.1.Олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, НҮБ, түүний системийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх хүрээнд:

Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын пактын ээлжит илтгэлийг ГХЯ-аар дамжуулан НҮБ-ын Хүний эрхийн хороонд хүргүүлэв.

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-тай “Хүлээн авагч улсын гэрээ”-ний /Host country agreement/ төслийн орчуулгыг хянаж, ГХЯ-аас санал авахаар хүргүүлсэн.

Монгол Улсын Хууль зүйн яам, Оросын Холбооны Улсын Хууль зүйн яам хооронд байгуулсан хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн хүрээнд 2016-2018 онуудад хамтран ажиллах хөтөлбөрийг орчуулж айлын талд хүргүүлэв.

Бүгд Найрамдах Беларусь Улсын талтай эрх зүйн хүрээний хамтын ажиллагааны асуудлаар байгуулах баримт бичгүүдийн талаар зөвлөлдөх 2016 оны 3 дугаар сарын 9-11-ний өдөр уулзалт зохион байгуулж, баримт бичгүүдийг төслүүдийг эцэслэн тохиролцсон.

“Бүгд Найрамдах Казахстан Улсад байнга оршин сууж буй Монгол Улсын иргэд, Монгол Улсад байнга оршин сууж буй Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэд хялбаршуулсан журмаар харьяат болох, харьяатаас гаргах, хоёрдмол харьяалалтай, харьяалалгүй болох тохиолдлоос урьдчилан сэргийлэх” тухай хэлэлцээрийг байгуулах хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Хууль зүйн яамтай 5 дугаар сарын 24-ны өдөр эрх зүйн туслалцааны асуудлаар видео хурал хийв.

Үл хөдлөх хөрөнгийн асуудлаарх ажлын хэсгийн шинжээч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгийн жагсаалт, талбайн хэмжээ, төлбөр тооцооны асуудлаар тулгалт хийлээ.

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар болон Оросын Холбооны Улсын Эдийн засгийн хөгжлийн яамны харьяа Улсын бүртгэл, кадастр, зураг зүйн холбооны албаны хооронд байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг хянаж, хариуцсан агентлагт хүргүүлэв.

Монгол, Финландын Засгийн газар хоорондын комиссын 12 дугаар хуралдааны протоколын биелэлт, Монгол дахь Туркийн Элчин сайдын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Хуулийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны талаарх мэдээлэл, Монгол Туркийн Гадаад хэргийн яамдын Консулын зөвлөлдөх уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улс, БНХАУ-ын Гадаад хэргийн яамны хоорондын Консулын XVII зөвлөлдөх уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг тус тус гарган ГХЯ-нд хүргүүлэв.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Монгол, Хятадын хүмүүнлэгийн солилцооны хамтарсан зөвлөл байгуулах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төсөл, Итали болон Турк Улсын Засгийн газар хоорондын хамтарсан комиссуудын хуралдаанаар хэлэлцэх асуудал, Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын 14 дүгээр хуралдаанаар хэлэлцэх асуудал, “Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд хийсэн ажил, цаашид шийдвэрлүүлэх асуудал, “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн

хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын XIV хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл зэрэг 5 хөтөлбөр, төсөлтэй танилцан санал хүргүүлэв.

Хууль сахиулах их сургууль болон Францын Аюулгүй байдал, хууль зүйн салбарын удирдах албан хаагчдыг бэлтгэх үндэсний институт хооронд хамтран ажиллах хэлэлцээрийн төслийг хянаж буцаан хүргүүлэв.

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газартай байгуулсан гэрээний асуудлаар Унгарын мөнгөн тэмдэгт үйлдвэрлэгч компаниас ирүүлсэн албан бичиг, Австри Улсын Холбооны гэр бүл, залуучуудын сайдаас ирүүлсэн “Бие махбодийн шийтгэлээс ангид байх хүүхэд нас” сэдэвт өндөр түвшний дэлхийн бага хурлын урилгын орчуулгыг хийж, сайдад танилцуулав.

Манай талаас хүргүүлсэн “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн Туркийн Шүүх эмнэлгийн хүрээлэн хооронд хамтран ажиллах санамж бичиг”-ийн төсөлд Туркийн талаас ирүүлсэн хариу саналд, Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэнгийн 5 дугаар сард Япон Улсад хийх ажлын айлчлалын удирдамж, албан ёсны яриа, хэлэлцээний сэдэвт тусгах саналыг тус тус хүргүүлсэн.

5.2. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай, гэмт этгээд шилжүүлэх тухай, ялтан шилжүүлэх тухай олон улсын гэрээ байгуулах ажлын хүрээнд:

Бүгд Найрамдах Беларусь Улс, Монгол Улс хооронд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, иргэний болон худалдааны асуудлаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай, ялтан шилжүүлэх тухай гэрээ байгуулах хүрээнд айлын талын төлөөлөгчдийг хүлээн авч, хэлэлцээ хийв.

“Зохион байгуулалттай болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөл, “Монгол Улсын Хууль зүйн яам, Бүгд Найрамдах Австри Улсын Дотоод хэргийн яам хооронд цагдаагийн чиглэлээр хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг айлын талд хүргүүлэв.

Ялтан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан.

Монгол Улсын Хууль зүйн яам болон БНХАУ-ын Хууль зүйн яам хоорондын 2016-2018 онд хамтран ажиллах хөтөлбөрийг байгуулах хүрээнд ГХЯ-аар дамжуулан хариу хүргүүлсэн.

Монгол Улсын Хууль зүйн яам Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг шинэчлэхээр ажиллаж, Оросын талаас ирүүлсэн хэлэлцээрийн төсөл, Монгол Улсын Хууль Зүйн яам болон Бүгд Найрамдах Итали Улсын Үндэсний цагдаагийн газар, Карибинери болон Эдийн засгийн цагдаагийн газар хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах тухай ЦЕГ-аас ирүүлсэн төсөлд санал өгөв.

Монгол Улс, БНАСАУ хооронд ялтан шилжүүлэх тухай гэрээний төслийн санал айлын талаас ирүүлснийг хүлээн авч, орчуулгыг хийж байна.

Монгол Улс, Финланд Улсын Хууль зүйн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг бэлтгэн ГХЯ руу хүргүүлэв.

“Интерполын зорчих баримт бичгийг хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Засгийн газар, Олон улсын цагдаагийн байгууллага (Интерпол) хоорондын гэрээ”-ний төслийг хянаж, хариу санал хүргүүлсэн.

Эрх зүйн туслалцааны хүрээнд эхний хагас жилийн байдлаар нийт 119 эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээн авч холбогдох ажиллагааг хийж, нийт 8 өргөдөл хүлээн авч, нийт 44 иргэдэд холбогдох зөвлөгөө өгч ажилласан байна.

5.3. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ болон гадаад орны шүүх, арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулах талаар:

“Төмөртэй хүдэр” ХХК-ний БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын нэхэмжлэлтэй арбитрын маргааны хэргийн харьяалалыг хэлэлцэх шүүх хурлын дараа нэхэмжлэгч талаас гаргасан 2

гомдлын асуудлаар хариу тайлбар бэлтгэн арбитрын бүрэлдэхүүнд хүргүүлсэн бөгөөд шүүх бүрэлдэхүүнээс нэхэмжлэгч талын гомдлыг хүлээж авах боломжгүй гэсэн шийдвэрийг гаргасан.

Дээрх маргааны арбитрын бүрэлдэхүүний зардлын асуудлаар Засгийн газрын тогтоолын төсөл болон зөвлөх хуулийн фирмүүдийн ажлын хөлсний асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлэн ЗГ-ын тогтоол батлагдан гарсан.

Хан Ресорсезтэй байгуулах “Эксроу гэрээ”-ний төсөл болон “Эвлэрлийн болон үүргээс чөлөөлөх тухай гэрээ”-ний төсөл дээр хуулийн зөвлөх фирм болох Хоган Ловелсын хуульчидтай хамтран ажиллаж, Сангийн яаманд хүргүүлэв.

“Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой эрх зүйн маргаанаас урьдчилан сэргийлэх, маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, маргаан үүсэхэд баримтлах журам”-ын төсөл болон ЗГ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэлийн төсөлд холбогдох байгууллагын саналыг авч байна.

5.4. Олон улсын байгууллагын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:

Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Архивын ерөнхий газар, Хууль сахиулах их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хэрэгжүүлэх төслийн танилцуулга, төслийн саналыг холбогдох агентлагын төлөөлөлтэй хамтран боловсруулж, орчуулж Сангийн яаманд хүргүүлсэн.

БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Эрх зүйн шинэтгэл” багц төслийн боловсруулалтын чиглэлээр холбогдох агентлаг, байгууллагуудтай хамтран англи, монгол хэлээр төслийг боловсруулан Сангийн яам, БНСУ-ын Элчин сайдын яаманд хүргүүлэв.

БНСУ-ын Ерөнхий сайдын Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалтай холбогдуулан БНСУ-ын Ерөнхий прокурорын газраас хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх чиглэлээр олгодог хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд 2017 онд Монгол Улсад техникийн болон хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр ЦЕГ, ШШГЕГ, ШШҮХ, ХСИС хүрээнд хэрэгжүүлэх төслийн саналыг бэлтгэн ГХЯ-д хүргүүлэв.

Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх “Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх”, “Хууль зүйн салбарын чадавхийг бэхжүүлэх” төслийн уулзалтуудыг зохион байгуулж, төслийн харилцан ойлголцлын санамж бичгийг хянаж хүргүүлсэн.

БНХАУ-аас Монгол Улсад олгох буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийг боловсруулж, хүргүүлсэн.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-аас 2017 онд Монгол Улсад хэрэгжүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрт хамруулах санал, төслийг хүргүүлэв.

5.5. Зохион байгуулсан арга хэмжээ, айлчлал, уулзалт:

Хууль зүйн сайд Д.Дорлигжавын ХБНГУ-ын Олон Улсын Энх-Тайван, Эрх зүйт ёсны Макс Планкийн сан”-гийн захирал, Профессор Рюдигер Волфрумыг хүлээн авсан уулзалт, Австрали Улсаас Монголд суугаа Элчин сайд Жон Лэнгтри болон Австрали Улсын Элчин зөвлөх Майкл Виллард нарыг хүлээн авсан уулзалт, Туркийн Шүүх, прокурорын дээд зөвлөлийн ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Мэхмэт ЫЙЛМАЗ тэргүүтэй төлөөлөгчдийн уулзалтыг тус тус зохион байгуулсан.

ТНБД Ж.Баярцэцэгийн АНУ-ын Элсийн сайдын яамны Дэд тэргүүн К.Макбрайдыг хүлээн авч уулзсан уулзалт, Канад улсын Хууль зүйн яамны Олон улсын эрх зүйн хөтөлбөр, хамтын ажиллагааны асуудал хариуцсан зөвлөх Серж Лорти, Канад Улсын Холбооны шүүхийн ОУ-ын хөтөлбөр хариуцсан захирал Олег Шаков нартай уулзсан уулзалт, Дэлхийн Банкны Зохицуулалтын бодлого ба удирдлага хариуцсан тэргүүн Питер Ладегард тэргүүтэй төлөөлөгчдийн уулзалт, Дэлхийн Банкны ОУСК-ийн Ази, Номхон далайн бүсийн зохицуулагч хатагтай Женефертэй хийсэн уулзалт, Турк улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Мурат Каракгөзийг хүлээн авч уулзсан уулзалтыг тус тус зохион байгуулсан

Газар, хэлтсийн дарга нарын Францын Батлан хамгаалах яамны Зэвсэглэлийн ерөнхий газрын Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн дэд захирал, хошууч генерал Ж.Күскэр тэргүүтэй төлөөлөгчдийн уулзалт, ОУЭЗХБ-ын Монгол дахь төслийн удирдагч Карлос Эскудерогийн

уулзалт, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт болон Хүний эрхийн газрын сонгуулийн үнэлгээний багийн зөвлөх Стивен Мартин, Улву Акхундлу нарын уулзалтыг тус тус зохион байгуулав.

НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын энхийг сахиулах цагдаагийн ажиллагаанд Монгол Улсын цагдаагийн албан хаагчдыг оролцуулах хүрээнд НҮБ-ын Туслалцаа, үнэлгээний багийг Монгол Улсад 2016 оны 4 дүгээр сарын 1-нээс 9-ний өдрүүдэд ажиллуулав.

АНУ-ын "Warnath Group"-ээс санхүүжүүлж Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Хууль сахиулах, шүүх, прокурорын байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтыг 3 дугаар сард зохион байгуулсан.

Тайланд Улсад 5 зохион байгуулагдсан "НҮБ-ын хүний эрхийн гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтний сургагч багшийг бэлтгэх сургалт", "Мөнгө угаах" сэдэвт олон улсын хурал, ЕАБХАБ-ын "Women Leadership and Empowerment Initiative for Border Security and Management Agencies" төслийн хүрээнд Бүгд Найрамдах Финланд Улсад зохион байгуулагдсан Жендерийн тэгш байдлыг хангах уулзалтад холбогдох албан тушаалтныг хамруулах ажлыг зохион байгуулсан.

ЗУРГАА. БОДЛОГЫГ ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

6.1.Бодлогын хэрэгжилтийг зохицуулах, харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

"Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай", "Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам",

"Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүн"-ийг шинэчлэн байгуулах тухай, "Улсын хэмжээнд зохион байгуулагдах аж ахуйн нэгжийн тооллогын тов", "Барилга шилжүүлэх тухай", "Нээлттэй дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын зарим хэсгийг хүчингүй болгох тухай" зэрэг Засгийн газрын 6 тогтоолын төслийг боловсруулж, батлуулсан.

Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоол, 2008 оны 170 дугаар тогтоолд Засгийн газрын 2016.01.11-ний өдрийн 32, 33 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

"Хууль сахиулахын их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2015 оны 240 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулахаар яамдуудаас санал авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Хууль зүйн сайдын тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа "Сүлд биеийн тамир, спортын хороо байгуулах тухай", "ШШГЕГ-ын Төв архив байгуулах тухай" болон "Улсын бүртгэл статистикийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц", "Агентлаг, байгууллагуудын хөгжлийн стратегийн хөтөлбөр"-ийг тус тус боловсруулан батлуулсан.

Хууль зүйн сайдын тушаалаар "Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам", "Зорчигч, тээврийн хэрэгслийн хил нэвтрэлт, гадаад иргэдийн бүртгэл, хяналтын мэдээллийн цахим ситемийн үйл ажиллагааг зохион байгуулах журам", "Гэрч, хохирогчийг нүүлгэн шилжүүлэх журам", "Мэдээллийн нэгдсэн сүлжээ болон толгой компьютерийг ашиглах, түүнийг нууцыг хадгалах журам", "Цагдаагийн мэргэшсэн алба хаагч бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр, Цагдаагийн сургуульд суралцагч элсүүлэн суралцуулах журам", "АСЕМ-ын 11 дүгээр уулзалтын аюулгүй байдлыг ханган ажиллах Нэгдсэн удирдлагын төвийн ажиллах журам", 2016 онд импортлох галт зэвсэг, сумны төрөл, зориулалт, тоо хэмжээ", "Тахарын ерөнхий газрын Алба хаагчдын дүрэмт хувцас, хэрэглэлийн загвар, эдэлгээний норм" /нэмэлт оруулсан/, "Тахарын албаны үйл ажиллагааны жишиг хэмжээг тогтоох тухай" зэрэг 10 гаруй журмыг боловсруулан батлуулсан.

Хууль зүйн сайд, Гадаад хэргийн сайдын хамтарсан тушаалаар "Хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон Консулын газраас иргэний улсын бүртгэл хөтлөх заавар", Хууль зүйн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар "Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэдийн бүлгийг баг, хороонд ажиллуулах бүлгийн үлгэрчилсэн дүрэм", Эрүүл мэнд, спортын сайд, Хууль

зүйн сайдын хамтарсан тушаалаар "Цагдан хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам", Хууль зүйн, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан тушаалаар "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдалд дүгнэлт гаргах журам", Сангийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан тушаалаар "Галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив"-ыг батлуулсан.

Хууль зүйн сайдын тушаалаар "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө", "Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй холбоотой зөвшөөрлийн талаар санал гаргах Комиссын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө", "Монгол Улсад 2016 онд зохион байгуулагдах АСЕМ-ийн дээд түвшний уулзалтын аюулгүй байдал, улсын хил нэвтрэх асуудал хариуцсан ажлын хэсгийн төлөвлөгөө"-г тус тус батлуулсан.

Хууль зүйн тушаалаар "Аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллого явуулах тухай", "Төрийн тусгай хамгаалалтын газарт сум улсын хилээр оруулах зөвшөөрөл", Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар Банкны өр барагдуулах үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнийг батлуулан ажиллаж байна.

"Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам"-ын дагуу өргөдөл гаргасан хохирогчдод хохирлыг олгох асуудлыг Орон тооны бус сангийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Хууль зүйн сайдын тушаалаар 16 хохирогчдод 51.275.822 сая төгрөгийн нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн.

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар "Эрх зүйн мэдээлэл бэлтгэх түгээх аргачлал"-ыг батлуулсан.

6.2.Иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр:

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2016 онд харьяа агентлаг, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг"-г /нийт 79 заалттай/ боловсруулан ТНБД-аар батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.

"Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж удирдлагуудад танилцуулсан.

"Захиргааны ерөнхий хууль"-иар иргэдэд зориулсан эрх зүйн сургалтыг 6 дугаар сард орон даяар зохион байгуулсан.

Монголын үндэсний радиогоор сар бүр явуулдаг "Шинэ товчоо" радио зохиомжит нэвтрүүлгээр 2016 онд хууль тогтоомж сурталчлах ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөний дагуу "Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /шинэчилсэн найруулга/, "Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль", "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль", "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль" /Шинэчилсэн найруулга/, "Захиргааны ерөнхий хууль"-иар зохиомж бэлтгэн "Шинэ товчоо", МҮОНР-оор орон даяар нэвтрүүлж сурталчилсан.

Хууль зүйн сайдын тушаалаар "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын удирдах албан тушаалтнуудыг 2016 онд давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр"-ийг батлуулан сургалтуудыг зохион байгуулсан.

Бие даасан хөгжил ТББ-тай хамтран Хөдөлмөрийн мөлжлөгийн талаарх ойлголтыг өгөх зорилготой сургалтыг Нарантуул олон улсын худалдааны төвд хөдөлмөр эрхлэж буй 6-16 насны хүүхдүүдийн дунд зохион байгуулсан.

Хууль зүйн яам АНУ-ын Төрийн департаментын Олон улсын мансууруулах бодис, Хууль сахиулах үйл ажиллагааны товчоотой хамтран Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх сургалт, "Эрүүгийн эрх зүйн тогтолцооны хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлох нь" сургалтыг тус тус зохион байгуулсан.

Бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Дорнод, Багануур, Налайх, Орхон, Дорноговь, Замын-Үүд, Багануур, Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг тус бүрийн 1 цэцэрлэг, 3 бага ангийн багш нар, сургуулийн нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтыг явуулж байна.

Хууль зүйн яамны санхүүжилтээр ЦЕГ-ын харьяа Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны төв, Эрчүүд-эрүүл гэр бүл ТББ-тай хамтран гэр бүл хүчирхийлэл үйлдэгчдэд албадан сургалтыг ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд зохион байгуулан шүүгчийн шийтгэврээр баривчлагдан ирсэн 2000 орчим хүн хамрагдсан байна.

6.3.Орон нутгийн хууль зүйн албадтай харилцах, арга зүйн удирдлагаар хангах, чиглэлээр:

Хууль зүйн сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2016 онд хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн 2015 оны үйл ажиллагааг дүгнэн дүнг танилцуулсан.

Хууль зүйн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн “Ажил эрчимжүүлж, сахилга хариуцлагыг сайжруулах тухай” 1/3 тоот албан даалгаврын хэрэгжилтэд харьяа агентлаг байгууллагуудаас ирүүлсэн тайланд үнэлгээ хийж дүнг хүргүүлэв.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга нарын сургалт-семинарыг 2016 оны 4 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн талаарх мэдээллийг toj.gov.mn вэб сайтад баннар шинээр үүсгэн байршуулж, олон нийтэд мэдээлэх санг үүсгэн баяжуулах ажил хийгдэж байна.

6.4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сурталчилах ажлын хүрээнд сургалт зохион байгуулж, хөдөлмөр эрхэлдэг 200 орчим /давхардсан тоогоор/ хүүхдүүдийг долоо хоногт 2 удаа цуглуулан хамрууллаа. Мөн тэднийг өөрсдийнх нь хүсэлтийн дагуу нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрууллаа.

Хүн худалдаалах гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр "Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа тэмцье" сэдэвт 20 минутын нэвтрүүлэг, 2 шторкийг бэлтгэн Eagle TV, MYOHT, MNB зэрэг телевизүүдээр давтамжтайгаар, олон нийтийн газарт LCD дэлгэцээр тогтмол цацаж байна.

Гарын авлага материалыг эмхэтгэн хэвлүүлэх ажлыг хийж байна. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сэрэмжлүүлэг бүхий паспортын хавчуургыг хэвлэн хилийн боомтууд болон гадаад улсад суугаа элчин сайдын яамны консулын газарт хүргүүлэн тараалаа.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг хамгаалах байранд 600 орчим хохирогчийг байрлуулан туслалцаа үзүүлээд байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд цаг алдалгүй яаралтай тусламжийн тусгай дугаар 107-д 2500 иргэн түүний дотор хөдөө орон нутгаас 300 иргэн, нэр хаягаа хэлэхийг хүсээгүй 57 иргэн хандан гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл, зөвлөгөө авсан байна.

Гэгээ студитэй хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа тэмцье” сэдэвт 20 минутын нэвтрүүлэгийг бэлтгэн TV-5, Eagle TV-ээр цацаж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 мин 10 секундын шторкийг бэлтгэн телевиз, кинотеатруудад кино эхлэхийн өмнө гаргаж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудсыг хэвлүүлэн нийслэлийн 300 гаруй хороо, худагт байрлууллаа.

Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны төвтэй хамтран хүүхдийн хууль зүйн хорооны ажлыг идэвхжүүлэхэд арга зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох алба хаагчдыг сургах ажлыг 21 аймагт зохион байгуулсан.

Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн хурлаар сангийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн төслүүдийн хэрэгжилтийн тайлан болон Сангийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн.

“Архидан согтуурахтай тэмцэх сангийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Хууль зүйн сайдын 2016.02.23-ны өдрийн А/53 дугаар тушаалаар батлуулав. Сангийн зөвлөл 2016.05.24-ний өдөр хуралдаж, сангийн 2016 оны төлөвлөгөөнд Хууль зүйн сайдын 2016.05.30-ны өдрийн А/176 дугаар тушаалаар өөрчлөлт оруулж, сангийн зардлын зарцуулалтыг оновчтой байдлаар зохицуулах, архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран ажиллахаар гэрээ байгуулав.

Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, комисс шалгаруулалтыг явуулж 6 байгууллагын төслийг шалгаруулж, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Мөн архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр ЦЕГ-тай хамтран ажиллах тухай 2015 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 52 дугаар гэрээнд өөрчлөлт оруулан ажиллаж байна.

6.5.Хурал, зөвлөгөөн, хяналт, шалгалтын чиглэлээр:

Агентлаг, байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль тогтоол, дүрэм, журмуудад нийцлийн мониторинг хийх ажлыг тухайн байгууллагуудын хуулийн ажилтнуудтай хамтран хийж, гарсан судалгаа, танилцуулгын дагуу дүрэм, журмуудыг хуульд нийцүүлэн шинэчлэх, хүчингүй болгох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэлээр холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллагууд болон шашны урсгалын талаар судалгаа хийж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хууль зүйн сайдын тушаалаар байгуулан ажиллав. “Харьяа нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллага, тэдгээрийн урсгалын талаар шалгалт хийх ажлын удирдамж”-ийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүргүүлж, улсын хэмжээнд шалгалтын ажлыг зохион байгуулж, шалгалтын илтгэх хуудсыг УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны дарга болон Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Хууль зүйн сайдын тушаалаар Нотариатчийн мэргэшлийн шалгалтын товыг тогтоон, шалгалтыг 2016 оны 3 дугаар сард Нотариатчийн мэргэшлийн хороотой хамтран зохион байгуулсан.

2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөх “Захиргааны ерөнхий хууль”-иар яам, агентлагууд, нийслэл, дүүргүүдийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын ажилтнуудад зориулсан сургалтыг 2-р сарын 16-аас 4-р сарын 1-ний хооронд, 21 аймагт 4-р сарын 17-30-ны хооронд тус тус зохион байгуулж, нийт 100 гаруй удаагийн сургалтаар 7500 гаруй ажилтан албан хаагчийг хамруулсан байна.

Хууль зүйн сайдын тушаалаар Хууль сахиулах болон онцгой байдлын чиг үүрэгтэй байгууллагуудын Эмх замбараагүй байдал үүссэн үеийн хамтын ажиллагааг сайжруулах, тэдний албаны бэлэн байдлын жигдрэлт, бэлтгэлжилтийг хангах зорилгоор Команд штабын сургуулийг 2016 оны 5 дугаар сарын 17-19-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулсан.

“Дэлхий нийтийн хар тамхи, мансууралтай тэмцэх өдөр”-ийг 2016 оны 04 дүгээр сарын 28, 29-нд Замын-Үүд хилийн боомтод Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, “Цагаан соён” ТББ-уудтай хамтран зохион байгуулсан.

Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдаалах сонгон шалгаруулахыг хуулийн дагуу хийж, аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж хийсэн.

Хүн худалдаалахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, ИХШХЕГ, ЦЕГ-ын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан Монгол Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд тэр дундаа БНАСАУ, БНХАУ-ын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн болон цалин хөлс, амьдрах нөхцөл, хүний эрхтэй

холбоотой асуудлаар шалгалт явуулж, илэрсэн зөрчил дутагдлын талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулан холбогдох яамдад хүргүүлсэн.

"Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгарч буй асуудлууд" уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад нийслэлийн 9 дүүргийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, Хууль сахиулах их сургуулийн багш, Шуурхай удирдлагын төвийн алба хаагчид оролцлоо.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2016 оны 3 дугаар сарын 6-нд "Хууль сахиулах салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо" уулзалтыг зохион байгуулж, 150 орчим алба хаагчдыг хамруулсан.

Хууль зүйн сайдын баталсан удирдамжийн дагуу Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын тус аймгууд дахь алба, нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, дүнг танилцуулсан.

6.6. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын цахим нэгтгэлийн систем” байгуулах ажлын чиглэлээр:

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Прокурорын хяналт мониторингийн системээс шүүхэд шилжүүлсэн эрүүгийн 292 хавтаст хэргийн мэдээллийг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны бүртгэлийн 5215 хоригдлын мэдээллийг Үндэсний дата төвд байрлах хууль сахиулах, шүүхийн байгууллагын нэгдсэн мэдээллийн санд байнгын баяжилт хийхээр тохируулан шилжүүлсэн.

Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан төслийн багаас боловсруулж байгаа эрүүгийн хэрэг шүүхэд хянан шалгах бүртгэлийн програмыг шинэ хуулийн дагуу өөрчлөн боловсруулахаар ажиллаж байна. Шүүхийн ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, програмд орох нэмэлт өөрчлөлтийн процес зураглал, нэмэлт шаардлагыг хэлэлцэж байна.

Үндэсний дата төвд зохиомол сервер /Virtual server/ байрлуулан мэдээлэл дамжуулах сервис ажиллах, бүртгэлийн байгууллагын мэдээллээс иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн мэдээллийг шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүртгэлийн системд дамжуулах зорилгоор ашиглаж байна. Дата төвд байршиж байгаа дээрх сервер нь багтаамжийн хувьд хүрэлцэхгүй байгаа тул цаашид хууль шүүхийн байгууллагуудын харилцан өгөгдөл солилцох дундын нэгдсэн сангийн тасралтгүй ажиллагааг хангах тусдаа сервер компьютерт шилжүүлэн ҮДТ-д байршуулах шаардлагатай байгаа талаар удирдлагуудад танилцуулсан.

ДОЛОО. ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ДОТООД АУДИТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

7.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын талаар:

Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний 11 агентлаг, байгууллагын 2015 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэцүүлж, ЗГХЭГ-т хүргүүлсэн.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-т заасан Хууль зүйн сайдын гүйцэтгэх арга хэмжээний хэрэгжилтийн байдал, Аймаг, нийслэлийн Засаг даргын Хууль зүйн сайдтай байгуулсан 2015 оны гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх тухай хөтөлбөр”, “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөр”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”, “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, “Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр”, “Хорих ангийн дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөрийн”-үүдийн 2015 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн 2015 оны хэрэгжилт, “GIZ-ээс ХЗЯ-нд

хэрэгжүүлж буй төсөл"-ийн 2015 оны биелэлт, тайлан, ХЗЯ-ны 2015 оны үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох аргачлалыг боловсруулан, аргачлалыг эцэслэн боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Ерөнхийлөгчийн зарлиг, хууль тогтоомж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 156 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”, “Хил хамгаалах байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”, “Үндэсний архивын байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”, “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”, “Шүүхийн шинжилгээний байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”, “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хөгжлийн стратеги хөтөлбөр”-т хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн, үнэлгээний үр дүнд авах арга хэмжээний талаар Хууль зүйн сайдын тушаал боловсруулан, батлуулсан.

ИХШХЕГ-ын зарим чиг үүрэг, аймгуудийн хуулийн хэлтсийн 2015 оны үйл ажиллагаа, ХЗЯ-нд хэрэгжиж буй “Хууль сахиулах байгууллагуудын цахим мэдээллийн төв” төслийн төлөвлөгөөний биелэлт, ХЗЯ-ны 1 дүгээр улирлын тайлан, “Able систем”-ийн албан бичиг програмын ашиглалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

7.2.Салбарын хяналт шалгалтын чиглэлээр:

Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ХШҮДАГ-ын даргын өгсөн үүргийн дагуу ЦЕГ-ын “Цагаан шонхор” УУГ-т шалгалт хийж, дүнг удирдлагад танилцуулсан.

7.3.Дотоод аудитын чиглэлээр:

Хууль зүйн сайд, Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу дараах үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, дүнг удирдлагад танилцуулж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

“Архидан согтуурахтай тэмцэх сан”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр”-ийн санхүүжилтээр 2015-2016 онд гэрээ байгуулан хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагын гэрээний хэрэгжилт, үр дүн, санхүүгийн үйл ажиллагаа, Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаа, ИХШХЕГ-ын санхүүгийн үйл ажиллагаа, ШШҮХ-нд дотоод аудит хийж, дүнг танилцуулсан.

Хууль зүйн сайдын баталсан удирдамжийн дагуу Хил хамгаалах ерөнхий газар, Хилийн хангалт үйлчилгээний 243 дугаар ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт, ИХШХЕГ-ын Хяналт шалгалтын газарт чиг үүргийн үнэлгэ хийж, дүнг танилцуулсан.

ХЗС-ын баталсан удирдамжийн дагуу 2 төсөл хөтөлбөр, 4 агентлагын санхүү, бүртгэл, үндсэн үйл ажиллагааны зарим чиг үүрэгт дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, Хууль зүйн яамны Жижиг мөнгөн сангийн 2016 оны 1 дүгээр улирлын орлого, зарцуулалтад хяналт шалгалт, Хууль зүйн яамны Төрийн сангийн 2016 оны эхний улирлын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүнг удирдлагад танилцуулсан.

Дотоод аудитын журамд заасан цагалбарын дагуу харьяа агентлаг, байгууллагын “Эрсдэлийн үнэлгээ”-г нэгтгэн Эрсдэлийн үнэлгээнд суурилсан Дотоод аудитын 2016 оны жилийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан.

Дотоод аудитын төлөвлөгөөний биелэлтийг удирдлагад танилцуулан, агентлаг, байгууллагуудад Хууль зүйн сайдын албан даалгавар хүргүүлсэн.

Зайны хяналтын системийн тогтолцоог нэвтрүүлэх, ажлын даалгавар, гэрээний төслийг боловсруулж, удирдлагад танилцуулан ажил гүйцэтгэх гэрээг 2016 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр “Ухаалаг засаглал” ТББ-тай байгуулан ажиллаж байна.

Засгийн газрын Худалдан авах ажиллагааны хялбаршуулсан гарын авлагыг хэвлүүлж, харьяа агентлаг байгууллагуудад хүргүүлсэн.

Салбарын статистик мэдээллийг сар бүр нэгтгэн удирдлагуудад танилцуулсан.

Хууль зүйн яам болон харьяа агентлаг, байгууллагын шилэн дансны мэдээллийг нэгтгэн Сангийн яам яам, Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагуудын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Харьяа агентлаг, байгууллагуудын дотоод аудит хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах, туршлага солилцох аудитыг ХХЕГ-ын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн байдалд 15 хоногийн практик сургалтыг зохион байгуулсан.

Харьяа агентлаг, байгууллагын ХШҮДА-ын нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэдээлэл солилцох, шуурхай удирдлагаар хангах ажлын хүрээнд сар бүр уулзалт зохион байгуулж байна.

ДҮГНЭЛТ:

Тус яам 2016 оны эхний хагас жилд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн хөгжлийн цогц бодлого, Хууль зүйн сайдын эрхлэх хүрээний асуудлаар УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтоо бүрэн хэрэгжүүлэн ажилласан.

-----oOo-----

